



МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000276586

2023.03.02

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011849232

/ Хувийн хэргийн дугаар /

6999581

/ Регистрийн дугаар /

Шивээхүрэн төмөр зам

Хязгаарлагдмал хариуцлагатай  
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2023.02.28

/ он, сар, өдөр /

46100

/ кий /

Толбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа

/ үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

2

/ гишүүдийн тоо /

1,000.00

/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, 9, 4 давхарт, Утас1: 70003203, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ

/гэмдэг/ 3

У.МАНДАХТУЯА

/гарын үсэг/

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга                                                                                     | Бүртгэсэн  |                       |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------------------|
|     |                                                                                                                | Огноо      | Ажилтан тэмдэг        |
| 1   | Амаржаргал овогтой Хүрэлбат-г Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2023.03.02 | У.Мандахтуяа<br>11/78 |



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000276586

Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 2 дугаар  
сарын 28-ны өдрийн хурлын ..... дугаартай  
тогтоолын хавсралт



**“ШИВЭЭХҮРЭН ТӨМӨР ЗАМ”  
ХХК-ИЙН ДҮРЭМ**

Улаанбаатар хот  
2023 он

## “ШИВЭЭХҮРЭН ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН ДҮРЭМ

Төмөр замын тээврийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 232 дугаар тогтоол, 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 32-р тэмдэглэл, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг тус тус үндэслэн дор дурдсан талууд (цаашид тус бүрд нь “Хувьцаа эзэмшигч”, хамтад нь “Хувьцаа эзэмшигчид” гэх) энэхүү “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийн дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийг 2023 оны 2 дугаар сарын 28 ны одор Улаанбаатар хотноо батлав. Үүнд:

1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан (Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам-62, Юнион Бюлдинг төвийн 7 давхар), Улсын бүртгэлийн 9012001025, регистрийн 5214203 тоот дугаартай “Монголын Төмөр Зам” ТӨХК (цаашид “МТЗ” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал П. Ганхүү;
2. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан (Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, 9-р байр 4 давхар), Улсын бүртгэлийн 9011701119, регистрийн 6236707 тоот дугаартай “Нарийн сухайтын төмөр зам” ХХК (цаашид “НСТЗ” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Т.Батмагнай;

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Дүрэм нь “Шивээхүрэн төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Компани” гэх)-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдах байгууллагууд, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон үндсэн баримт бичиг болно.
- 1.2. Хувьцаа эзэмшигчдийн хамтын ажиллагааны зорилго нь Шивээхүрэн - Сэхэ хилийн боомтын зориулалттай төмөр замын суурь бүтэц шинээр барих, түүнд шаардлагатай зээлийн санхүүжилт хийх, суурь бүтцийг хамтран ашиглахад оршино.
- 1.3. Компани нь Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь энэхүү дүрмээр хязгаарлагддаг Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани байна.

### ХОЁР. КОМПАНИЙН НЭР, ХАЯГ

- 2.1. Компанийн оноосон нэр:

Монгол хэлээр:

Бүтэн нэр: “Шивээхүрэн төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай Компани

Товчилсон нэр: “Шивээхүрэн төмөр зам” ХХК.

Англи хэлээр:

Бүтэн нэр: “Shiveekhuren tumur zam” Limited liability company

Товчилсон нэр: “Shiveekhuren tumur zam” LLC.



2.2. Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, 9-р байр 4 давхар, утас: +976 70003203

2.3. Хамтарсан Компанийн Үүсгэн байгуулагч, Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

| №  | Хувьцаа эзэмшигч               | Регистрийн дугаар | Хаяг:                                                                                                 | Утас:    |
|----|--------------------------------|-------------------|-------------------------------------------------------------------------------------------------------|----------|
| 1. | “Монголын төмөр зам” ТӨХК      | 5214203           | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам-62, Юнион Бюлдинг төвийн 7 давхар | 70106611 |
| 2. | “Нарийнсухайтын төмөр зам” ХХК | 6236707           | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, 9-р байр 4 давхар           | 70003203 |

### **ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ХЭМЖЭЭ**

- 3.1. Компани нь дор дурдсан үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үүнд:
- 3.1.1. Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийх бөөний худалдаа;
- 3.2. Компани нь энэхүү Дүрмийн 1.2-д заасан үйл ажиллагааг холбогдох тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.
- 3.3. Энэхүү Дүрмийн 1.2-д заасан төмөр замын суурь бүтэц шинээр барих, зээлийн санхүүжилт хийх, бүтээн байгуулалтын ажлыг НСТЗ бүрэн хариуцна.
- 3.4. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэхүү дүрмээр хязгаарлагдана.
- 3.5. Компани нь өөрийн нэрийн өмнөөс Монголын болон гадаадын хувь хүн, байгууллагуудтай гэрээ хэлцэл хийх, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг эдлэх, үүрэг хүлээх, шүүх, арбитрын ажиллагаанд эрх бүхий тал болон оролцох эрхтэй.
- 3.6. Компани нь Хувьцаа эзэмшигчдийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хүлээхгүй бөгөөд өөрийн өмч хөрөнгөөр компанийн өр төлбөрийг хариуцна.
- 3.7. Компани нь Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон хилийн чанадад салбар байгуулж болно.
- 3.8. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулах бөгөөд албан ёсны болон ажлын хэл нь монгол хэл байна.

### **ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА**

- 4.1. Компани нь нэг бүр нь 1 000 (нэг мянга)-н төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1 000 (нэг мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 1 000 000 (нэг сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.



4.2.Талууд дор дурдсан хэмжээгээр Компанид хувьцаа эзэмшинэ. Үүнд:

| №  | Хувьцаа эзэмшигчид             | Хувьцааны тоо ширхэг | Хувьцааны нийт үнэ (төгрөгөөр) | Эзэмшиж буй хувь |
|----|--------------------------------|----------------------|--------------------------------|------------------|
| 1. | “Монголын төмөр зам” ТӨХК      | 510                  | 510 000                        | 51%              |
| 2. | “Нарийнсухайтын төмөр зам” ХХК | 490                  | 490 000                        | 49%              |

- 4.3.Хувьцаа нь Компанид хөрөнгө оруулсныг гэрчлэх Хувьцаа эзэмшигчдийн баталгаа мөн бөгөөд эзэмшиж буй хувьцаандаа хувь тэнцүүлэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх, компаниас ногдол ашиг хүртэх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг эрхийг баталгаажуулахад ариуулсан, ашигттай захишгүйн үндсэн дээр худалдан авсан үнэт цаас болно.
- 4.4.Хувьцаа нь энгийн хэлбэртэй, нэгж хувьцаа тус бүрд нэг саналын эрхтэй байна.
- 4.5.Компани нь Хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг үндэслэн нэмж хувьцаа гаргах, давуу эрхийн хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион, бонд, бусад үнэт цаас гаргах замаар хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж болно.
- 4.6.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээг өөрчлөх болон хөрөнгө оруулагч (хувьцаа эзэмшигч) нэмэх асуудлыг Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

#### ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1.Хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд зааснаас гадна хувь нийлүүлсэн хөрөнгө, эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
- 5.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
- 5.1.2.Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн Дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах;
- 5.1.3.НСТЗ нь энэхүү дүрэмд заасан төмөр замын суурь бүтэц барихад оруулсан зээлийн хөрөнгө оруулалтаа төмөр замын тээврээр нүүрс экспортлох замаар Компанийн орлогоос бүрэн нөхөх;
- 5.1.4.Төмөр замын ашиглалт, удирдлага, менежмент болон Компанийн бусад асуудлыг шийдвэрлэхэд оролцох;
- 5.1.5.Эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр холбогдох татвар суутгагдсаны дараах ногдол ашгаа авах;
- 5.1.6.Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- 5.2.Хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 5.2.1. МТЗ нь энэхүү дүрмийн 3.1.1, 3.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хариуцах.
- 5.2.2. НСТЗ нь төмөр замын суурь бүтэц барихад шаардлагатай зээлийн хөрөнгө оруулалт болон барилга угсралтыг хариуцах.



- 5.2.1. МТЗ нь энэхүү дүрмийн 3.1.1, 3.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хариуцах.
- 5.2.2. НСТЗ нь төмөр замын суурь бүтэц барихад шаардлагатай зээлийн санхүүжилт болон барилга угсралтыг хариуцах.
- 5.2.3. НСТЗ нь Энэхүү дүрмийн 5.1.3-т заасан нөхцөл биеллэгд өөрийн эзэмшлийн 49 хувийн хувьцааг МТЗ-д үнэ төлбөргүй шилжүүлэх
- 5.2.4. Талуудын тохиролцсон ногдол ашиг олгох нөхцөл бүрдсэн тохиолдолд холбогдох шийдвэрийг гаргах;
- 5.2.5. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх,
- 5.2.6 Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа гэрээнд Хувьцаа эзэмшигч үүрэг хүлээсэн бол тухайн гэрээгээр хүлээсэн үүргээ компанийн ашиг сонирхолд нийцүүлэн үнэнч шударгаар биелүүлэх,
- 5.2.8. Хувьцаа эзэмшигч нь Компанитай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол үүний улмаас үүсэх хохирол, хариуцлагыг эзэмшиж буй хувьцаа, ногдол ашгийн хэмжээгээр хязгаарлахгүйгээр тухайн хувьцаа эзэмшигч бүрэн хариуцах,
- 5.2.9. Өөрийн эзэмшлийн хувьцаа, Компанид оруулсан хөрөнгө, мөн менежмент шилжих үед бүртгэлд байгаа хөрөнгө нь аливаа маргаангүй, эрхийн зөрчилгүй байлгах,
- 5.2.10. Хэрэв хувьцаагаа худалдах, шилжүүлэх тохиолдолд тэргүүн ээлжинд ногоо хувьцаа эзэмшигчдээ санал тавих,
- 5.2.11. Энэ дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон зээлийн санхүүжилтийн гэрээнд заасан бусад үүргийг биелүүлэх.
- 5.3. Хувьцаа эзэмшигчид нь Компанийн гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг гагцхүү компанид оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцна.
- 5.4. Талууд нь компанид хувь нийлүүлсэн хөрөнгөөрөө компанийн өмнө хариуцлага хүлээх ба Талууд өөрсдийн эзэмшиж буй хувийн дагуу оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь тэнцүүлэн ашиг, эрсдэл болон алдагдлыг хуваалцана.
- 5.5. Хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаанд оролцохдоо эрх, үүргээ тус тусдаа эдэлж, биелүүлэх бөгөөд хамтын хариуцлага хүлээхгүй.

### **ЗУРГАА. КОМПАНИЙН САНХҮҮЖИЛТ**

- 6.1. НСТЗ нь Төмөр замын суурь бүтэц барьж ашиглалтад оруулах ажлын зээлийн санхүүжилтийг өөрийн эзэмшиж буй хувьцаанд ногдох хэмжээнээс үл хамаарч бүхэлд нь хариуцна.
- 6.2. Төслийн ажилд нэмэлт санхүүжилт шаардлагатай бол энэ асуудлыг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.
- 6.3. Нэмэлт хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх тохиолдолд дор дурдсан хэлбэрээр санхүүжилтийг хийж болно. Үүнд:
- 6.3.1. Хувьцаа эзэмшигчээс компанид биет болон биет бус байдлаар нэмэлт хөрөнгө оруулалт хийх;
- 6.3.2. Зээл авах;
- 6.3.3. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа, давуу эрхийн хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион, фьючерс, бонд зэрэг хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргах;

- 6.3.4. Санхүүжилтийн зах зээлд мөрдөгддөг бусад арга хэлбэр.
- 6.4. Санхүүжилт авахын тулд Хувьцаа эзэмшигч нь холбогдох олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудад шаардлагатай баталгаа, нотолгоо, батлан даалт болон бусад баримт бичгийг гаргаж өгнө.
- 6.5. Компани нь нэмэлт хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах замаар өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх тохиолдолд нэмж гаргахаар шийдвэрлэсэн энгийн хувьцаа болон хувьцаанд хөрвөх үнэт цаасны тоо, төрөл, хугацаа, хувьцааны үнэ, төлбөрийн хэлбэр, бусад нөхцөлүүдийг хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр тогтооно. Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн компаниас гаргасан нэмэлт хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
- 6.6. Санхүүжилттэй холбоотой бусад асуудлыг зээлийн санхүүжилтийн гэрээгээр зохицуулна.

### **ДОЛОО. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ**

- 7.1. Хувьцаа эзэмшигчид Дүрмийн 4.2-т заасан хувь хэмжээнд тэнцүүлэн ногдол ашиг хуваарилах шийдвэрийг хэдийд ч гаргаж болно. Тус шийдвэрт Хувьцаа эзэмшигчид хуваарилах ногдол ашгийн хэмжээг тусгасан байна.
- 7.2. Дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд Хамтарсан компани нь Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилна. Үүнд:
- 7.2.1. НСТЗ нь төмөр замын суурь бүтэц шинээр барих, ашиглалтад оруулах төслийн зээлийн санхүүжилтээ нөхсөн байх;
- 7.2.2. Компани нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхээр төслийн хүрээнд зээл авсан бол тухайн зээлийг эргэн төлсөн байх;
- 7.2.3. Ногдол ашиг хуваарилсны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх;
- 7.2.4. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны зардал, татвар хураамж, ажиллагсдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эргэлтийн хөрөнгийн нийлбэрээс их байх.

### **НАЙМ. ХУВЬЦААГ ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХ**

- 8.1. Хувьцаа эзэмшигч нь эзэмшиж буй хувьцаа, хувь эзэмших эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдах буюу шилжүүлэх саналтай бол энэ тухайгаа хувьцаа шилжүүлэх буюу худалдах нөхцөлийн хамт нөгөө Хувьцаа эзэмшигч талд санал болгох бөгөөд нөгөө тал эзэмшиж буй хувьцаандаа хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд хувьцааг шилжүүлэн авах буюу худалдан авах давуу эрхийг олгоно. Энэхүү Саналд дараах нөхцөлийг тусгана. Үүнд:
- 8.1.1. Худалдах хувьцааны тоо болон үнэ;
- 8.1.2. Хувьцааг худалдахаар санал болгож буй бусад нөхцөл;
- 8.1.3. Гуравдагч этгээдийн тухай мэдээлэл.
- 8.2. Хувьцаа эзэмшигч нь гэрээний 8.1-д заасан саналыг хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх, эсвэл давуу эрхээсээ татгалзаж буй талаар хариу мэдэгдлийг ирүүлнэ.
- 8.3. Давуу эрхээсээ татгалзсан тохиолдолд Шилжүүлэгч тал нь хувьцааг зөвхөн нөгөө талын хүлээн зөвшөөрсөн гуравдагч этгээдэд Хувьцаа эзэмшигчид санал болгосон үнээс доошгүй үнэ, нөхцөлөөр шилжүүлж, худалдана.

- 8.4. Хувьцаа буюу эрх шилжүүлэн авагч нь Шилжүүлэгч Хувьцаа эзэмшигчийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, нөгөө Хувьцаа эзэмшигч болон Компанийн өмнө хүлээсэн өр төлбөрийг бүрэн хариуцах ба Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон Дүрмийг удирдлага болгож, эдлэх эрх, үүргийг хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлж Хүлээн авах баримт бичигт гарын үсэг зурна.
- 8.5. Хувьцаа худалдах, шилжүүлэхэд тавигдах энэхүү Гэрээний 8.1-8.3-д заасан шаардлагыг зөрчиж хийгдсэн шилжүүлгийг хүчин төгөлдөр бусад тооцож Компани бүртгэхгүй.
- 8.6. Аль нэг Хувьцаа эзэмшигч Тал нь шаардлагатай тохиолдолд нөгөө Хувьцаа эзэмшигч Талдаа урьдчилан бичгээр мэдэгдэж зөвшөөрөл авсны үндсэн дээр Компанид эзэмшиж буй өөрийн хувьцаа болон ногдол ашгийг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагад барьцаалах, түүгээр баталгаа, батлан даалт гаргаж болно.

### **ЕС. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО**

- 9.1. Компани нь удирдлага, зохион байгуулалтын хувьд дор дурдсан бүтэцтэй байна.  
Үүнд:
- 9.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал;
  - 9.1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөл,
  - 9.1.3. Хяналтын зөвлөл;
  - 9.1.4. Гүйцэтгэх удирдлага.

### **АРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

- 10.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 10.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна. Ээлжит бус хурлыг шаардлагатай тохиолдолд ТУЗ, эсвэл саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан тохиолдолд зарлан хуралдуулна.
- 10.3. Дор дурдсан асуудлуудыг гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:
- 10.3.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүнийг шинэчлэн батлах, Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;
  - 10.3.2. Ногдол ашгийн хэмжээ, түүнийг хуваарилах талаар ТУЗ-өөс ирүүлсэн саналыг хэлэлцэн батлах;
  - 10.3.3. Нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - 10.3.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээг өөрчлөх болон хөрөнгө оруулагч (хувьцаа эзэмшигч) нэмэх асуудлыг ТУЗ-ийн саналыг үндэслэн шийдвэрлэх;
  - 10.3.5. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах түүний тоог тогтоох;
  - 10.3.6. Компанийг татан буулгах комиссыг байгуулах, хараат болон охин компани байгуулах;
  - 10.3.7. Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх;

- 10.3.8. ТУЗ-өөс шийдвэрлүүлэхээр ирүүлсэн их хэмжээний болон сонирхлын зорчилтэй хэлцэл хийх зовшоорол олгох, тэдгээрийг батлах;
- 10.3.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 10.3.10. Компанийн удирдлага менежментийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх;
- 10.3.11. Компанид шаардлагатай санхүүжилтийн асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн Гэрээнд заасны дагуу шийдвэрлэх;
- 10.3.12. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох, чөлөөлөх, тэдгээрийн цалин, урамшууллыг тогтоох;
- 10.3.13. ТУЗ-ийн шийдвэрийг Монгол Улсын хууль тогтоомж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцээгүй гэж үзвэл өөрчлөх, хүчингүй болгох;
- 10.3.14. ТУЗ-ийн хурлын тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд.
- 10.4. Нийт гаргасан хувьцааны дийлэнх олонх /66 хувь/-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид биечлэн буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр (эсвэл телефон болон видео конференцээр) дамжуулан хуралд оролцсоноор Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэн гэж үзэх бөгөөд хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар гарсан шийдвэрийг хүчинтэйд тооцно.
- 10.5. Хурлын ирц товлосон хугацаанаас хойш 60 минутын дотор бүрдэхгүй бол Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахгүй бөгөөд хойшлогдсон хурлыг ажлын 14 хоногийн дотор шинээр зарлан хуралдуулна. Энэ хурлын ирц нь Компанийн гаргасан саналын эрх бүхий Хувьцааны дийлэнх олонх /66 хувь/-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор бүрдэнэ.
- 10.6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийлгүйгээр эчнээ санал хураалтаар тогтоол гаргаж болно.
- 10.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа бусад асуудлаар Хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшилд буй хувьцааны тоотой тэнцүү санал өгнө.
- 10.8. Хувьцаа эзэмшигчид аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасан хувь хэмжээгээр шийдвэрлэнэ.
- 10.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэхүү дүрмийн 10.3.3, 10.3.5-д заасан асуудлуудыг 100% бүрэн ирцтэй, Талуудын нэгдсэн (100%) саналаар шийдвэрлэнэ.
- 10.10. Хувьцаа эзэмшигчдээс гаргасан шийдвэр нь Компанийн бүхий л нэгж хэсэг, ажиллагсдын заавал дагаж мөрдөх ёстой шийдвэр байна.

#### **АРВАН НЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

- 11.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) байна.
- 11.2. ТУЗ нь 9 гишүүнтэй байна. МТЗ-аас 5, НСТЗ-аас 4 гишүүнийг нэр дэвшүүлэн 3 жил (гурав) -ийн хугацаатай томилно.
- 11.3. Компанийн ТУЗ-ийн даргыг МТЗ-аас нэр дэвшүүлэн ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар 3 жилээр томилно.
- 11.4. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн хурлыг зохион байгуулах, хурлын тогтоолыг бичгээр үйлдэх, Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлагад хэлэлцэх асуудлын тухай мэдээллээр хангах эрх, үүрэг бүхий нарийн бичгийн даргыг 3 (гурав)

жилийн хугацаатай томилох бөгөөд томилсон этгээд нь нарийн бичгийн даргыг эгүүлэн татаж болно.

11.5. ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын онцгой эрхээс бусад дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 11.6.1. Хамтарсан компанийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг Компанийн нэрийн өмнөөс шийдвэрлэх;
- 11.6.2. Гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- 11.6.3. Хамтарсан компанийн бодлого, зорилтыг тодорхойлох, стратегийн шийдвэр гаргахад хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх;
- 11.6.4. Компанийн ажлын тайлан, үр дүн, дараа жилийн төсөв, Бизнес төлөвлөгөөг хэлэлцэж батлах, эдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах, биелэлтэд хяналт тавих;
- 11.6.5. Санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайланг хэлэлцэх;
- 11.6.6. Компанийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг хэлэлцэж батлах;
- 11.6.7. Гүйцэтгэх удирдлага нь энэхүү Дүрэм болон Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасан үүргийг зохих ёсоор биелүүлээгүй, ТУЗ-өөс гаргасан шийдвэр, үүрэг даалгавар, төлөвлөгөөт зорилтыг хангалттай биелүүлээгүй бол ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж Гүйцэтгэх удирдлагад хугацаатай үүрэг даалгавар өгч арилгах, засуулах арга хэмжээ авах, үр дүнгүй ажилласан бол үүрэгт ажлаас нь чөлөөлөх, шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх удирдлагад Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээнд заасан үндэслэлээр хариуцлага тооцох;
- 11.6.8. Гүйцэтгэх удирдлагад их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийх зөвшөөрөл олгох.
- 11.6.9. Гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх, ажил үүргийг нь үнэлж дүгнэх, үр дүнтэй ажилласан бол хугацааг сунгах;
- 11.6.10. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалин хөлс, шагнал урамшууллын хэмжээг хэлэлцэн батлах,
- 11.6.11. Зээлийн санхүүжилтийн зардлууд, төрлийг тогтоох, зээлийн санхүүжилтээр тооцох биет хөрөнгө, ажил үйлчилгээний үнэлгээг шийдвэрлэх,
- 11.6.12. Төмөр замын төсөл ашиглалтад орсоны дараа нийт */биет хөрөнгө, мөнгөн хөрөнгө, ажил үйлчилгээ үзүүлсэн/* оруулалтын хэмжээг баталгаажуулах.
- 11.6.13. Энэхүү Дүрэмд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд ногдол ашиг олгох саналыг боловсруулж, хэмжээг тодорхойлон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах;
- 11.6.14. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх тухай санал гаргах;
- 11.6.15. ТУЗ-ийн хурлаар их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах;
- 11.6.16. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын товыг тогтоох;
- 11.6.17. Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгө, тусгай зөвшөөрөл болон дагалдах эд хөрөнгө, бусад эрхийн зах зээлийн үнийг тогтоох, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээний компанийн үйлчилгээ авах;
- 11.6.18. Хувьцаа эзэмшигч болон гуравдагч этгээдүүдэд үзүүлэх үндсэн үйлчилгээний үнэ, тарифыг хэлэлцэн батлах;

- 11.6.19. Компанийн өөрийн хөрөнгийн таван хувиас дээш хэмжээний хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг гаргах; Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх компанийг сонгож батлах;
- 11.6.20. Охин, хараат компанийн үйл ажиллагаанд Компанийг төлөөлөх этгээдийг томилох, эрх, үүргийг тодорхойлох;
- 11.6.21. Охин, хараат компанийн үйл ажиллагаанд Компанийг төлөөлөх ТУЗ-д ажиллах гишүүдийг сонгох, Гүйцэтгэх удирдлагын багт ажиллуулах этгээдийг томилох, эрх, үүргийг тодорхойлох;
- 11.6.22. Компанийн тухай хууль, Компанийн дүрэм түүнчлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас олгосон бусад бүрэн эрх.

### **АРВАН ХОЁР. ТУЗ-ИЙН ХУРЛЫН ИРЦ, ШИЙДВЭР**

- 12.1. ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Ээлжит болон ээлжит бус хуралдааныг гишүүдийн 1/3 –ийн шаардсанаар ТУЗ-ийн дарга зарлан хуралдуулна. Гүйцэтгэх захирлын санаачилгаар нэмэлт хуралдааныг зарлан хуралдуулж болох бөгөөд 7 хоногийн дотор ээлжит бус хурлыг зохион байгуулах асуудлыг ТУЗ-ийн дарга шийдвэрлэнэ.
- 12.2. Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн Даргын зааварчилгааны дагуу ТУЗ-ийн гишүүд, Компанийн гүйцэтгэх удирдлагад ТУЗ-ийн ээлжит хурал болохоос 7 (долоо)-оос доошгүй өдрийн өмнө хурал болох өдөр, цаг, газрын талаар дурдаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, тогтоолын төсөл болон бусад материалыг хавсаргасан бичгэн мэдэгдлийг Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх захиралд хүргүүлнэ.
- 12.3. Хэрэв ТУЗ-ийн гишүүд биечлэн уулзах үед хурлаар хэлэлцэх асуудлыг баталсан бол тухайн хурлын зарыг тусгайлан хүргэх шаардлагагүй.
- 12.4. Хурлыг Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг эсхүл ТУЗ-өөс тодорхойлсон газар зохион байгуулна.
- 12.5. Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт мэдээлэл авах эрхтэй ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга мэдээллийг өгнө.
- 12.6. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх /66 хувь/ нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирц бүрдээгүй тохиолдолд хуралдахыг хориглоно. Хойшлогдсон хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болохгүй. Хойшлогдсон хурлын ирц ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх хүрэлцэн ирснээр бүрдэнэ.
- 12.7. ТУЗ-ийн хурлыг видео болон бусад шууд дамжуулах харилцаа холбооны технологийг ашиглан хийж болно. ТУЗ-ийн хуралд биечлэн буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцоно. ТУЗ-ийн хуралд видео болон бусад шууд дамжуулах харилцаа холбооны технологийг ашиглан оролцож болно.
- 12.8. Хэрэв ТУЗ-ийн хуралд ТУЗ-ийн дарга хүрэлцэн ирээгүй бөгөөд түүний үүргийг төлөөлөн удирдах гишүүнийг томилоогүй бол гишүүд өөрсдийн дундаас нэг гишүүнийг тухайн хурлын даргаар томилно.
- 12.9. ТУЗ-ийн дарга, гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэх ба гишүүдийн дийлэнх олонхийн саналаар гаргасан шийдвэр хүчин төгөлдөр байна.
- 12.10. ТУЗ-өөс тогтоол гарах бөгөөд нарийн бичгийн дарга хурал болсноос хойш ажлын 5 хоногийн дотор бичгээр үйлдэж, ТУЗ-ийн даргаар батламжлуулан ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагад хүргүүлнэ.

- 12.11. ТУЗ нь ажиллах журмаа батлан түүнийг мөрдөж ажиллана. Хэрэв ТУЗ-ийн шийдвэр гаргахад санал нэгдэхгүй тохиолдолд шийдвэрлэж чадаагүй асуудлыг хурал болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор Хувьцаа эзэмшигч нарт хүргүүлнэ.

### **АРВАН ГУРАВ. ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА**

- 13.1. Компанийн Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий Хяналтын зөвлөлтэй байна.
- 13.2. Хяналтын зөвлөл нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Компанид хамгийн бага хувьцаа эзэмшиж буй Хувьцаа эзэмшигч НСТЗ нь 3 гишүүнийг томилно.
- 13.3. Хяналтын зөвлөл Гүйцэтгэх удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа хууль тогтоомж зөрчсөн, Хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхлыг илт хохироох тохиолдолд уг асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлж болно.
- 13.4. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална.
- 13.5. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. Компанийн Гүйцэтгэх захирлыг НСТЗ-аас нэр дэвшүүлэн ТУЗ-өөс томилно.
- 13.6. Гүйцэтгэх удирдлагын бусад ажилтныг ТУЗ-ийн саналыг харгалзан зохих мэргэжилтэй хүнийг сонгон шалгаруулах зарчмаар Гүйцэтгэх захирал томилно.
- 13.7. Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хууль, Хувьцаа эзэмшигчдийн баталсан чиглэл, шийдвэрүүдийг мөрдлөг болгон компанийн дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх захирал нь ажлаа ТУЗ-д тайлагнана.
- 13.8. Компанийн Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 13.8.1. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, Хувьцаа Эзэмшигчдийн болон ТУЗ-ийн шийдвэрт нийцүүлэн, батлагдсан төсвийн дагуу зохион байгуулж, удирдах;
- 13.8.2. Дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд бичгээр өгсөн итгэмжлэлгүйгээр бүх төрлийн харилцаанд компанийг төлөөлөх;
- 13.8.3. Компанийн нэрийн өмнөөс Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарахаас бусад гэрээ хэлэлцээрийг хийх;
- 13.8.4. Хувьцаа эзэмшигчдээс олгогдсон бүрэн эрхийн хүрээнд компанийн эд хөрөнгийг захиран зарцуулах, санхүүгийн баримтад гарын үсэг зурах;
- 13.8.5. Санхүүгийн тайлан тэнцэл, эд хөрөнгийн талаарх мэдээ мэдээлэл, ажлын тайлан, ирэх оны төлөвлөгөө, төсвийг зохих хугацаанд нь батлуулах;
- 13.8.6. Холбогдох хууль тогтоомж, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, ТУЗ-ийн шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хангуулах;
- 13.8.7. Компанийн удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох, техник тоног төхөөрөмж, технологийг сайжруулах, ажлын чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх, компанийн үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг зүй зохистой, өндөр үр ашигтай явуулах, санхүү төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, ноу-хау, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 13.8.8. Ажиллагсдын ажил үүргийн хуваарийг тогтоож Хөдөлмөрийн гэрээ байгуулах, компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдуулан тушаал гаргаж, биелэлтийг хангуулах, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах бусад дүрэм журмын биелэлтийг хангах;

- 13.8.9. Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг баталж мөрдүүлэх.
- 13.8.10. Батлагдсан төсвийн хэмжээнд нийцүүлэн компанийн ажиллагсдын үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох,
- 13.8.11. Компанийн эрх, хууль ёсны ашиг, сонирхол зөрчигдсөн тохиолдолд шүүх арбитрын байгууллагад нэхэмжлэл гомдол гаргах, компанийн эрх ашгийг хамгаалах.
- 13.8.12. ТУЗ-тэй байгуулсан гэрээний дагуу цалин авах, Компаниас гаргасан мэдээллийн бодит, үнэн зөвийг хариуцах.
- 13.8.13. Компанийн үйл ажиллагааны талаар эрх бүхий албан тушаалтнуудын шаардсан мэдээллийг бэлтгэж хүргүүлэх,
- 13.8.14. Гүйцэтгэх удирдлагын гэрээнд заасан бусад эрх, үүрэг.
- 13.9. Ажиллагсадтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх, цалин, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж олгох, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн бусад харилцааг Монгол Улсын Хөдөлмөрийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 13.10. Ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлнө.
- 13.11. Ерөнхий нягтлан бодогчийг НСТЗ аас санал болгосноор Гүйцэтгэх захирал томилно.
- 13.12. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд Их хэмжээний хэлцэл гэж үзэх босгыг зааж өгнө.

## **АРВАН ДӨРӨВ. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ, МЭДЭЭЛЭЛ**

### **14.1. Жилийн төлөвлөгөө, төсөв**

- 14.1.1. Гүйцэтгэх захирал Компанийн тухайн жилийн ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг дараа жилийн 1-р сарын 20, шинэ оны Бизнес төлөвлөгөө, Төсвийн төслийг өмнөх оны 12-р сарын 01-ны дотор тус тус боловсруулж, ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлсэн байх бөгөөд шинэ оны Бизнес төлөвлөгөө, Төсөв нь Компанийн төлөвлөж буй үйл ажиллагааны нарийвчилсан хөтөлбөр, төсөвлөсөн зардлын дэлгэрэнгүй задаргаа зэргийг агуулсан байна.
- 14.1.2. Шинэ оны Бизнес төлөвлөгөөг өмнөх оны 12 дугаар сарын 15-ны дотор, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэл, шинэ оны төсвийн төслийг дараа оны 2 сарын 1-ний дотор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж батална.
- 14.1.3. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс баталсан бизнес төлөвлөгөө, төсвийн дагуу компанийн үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн зөвшөөрөлтэйгөөр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 14.1.4. ТУЗ тухайн санхүүгийн жил эхлэхээс өмнө бизнес төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 14.1.5. Шинэ оны бизнес төлөвлөгөө, төсвийн төсөл, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хувьцаа эзэмшигчид танилцуулна.

### **14.2. Нягтлан бодох бүртгэлийн систем**

- 14.2.1. Санхүүгийн тайланг Монгол Улсын болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын (СТОУС) дагуу бэлдэж боловсруулна. Жил бүр бэлтгэсэн тайлангуудыг ТУЗ-д батлуулахаар танилцуулна. Аккруил дээр суурилсан

нягтлан бодох бүртгэл болон дебит, кредитийн аргыг данс тооцоо хөтлөхөд ашиглана.

14.2.2. Компанийн нягтлан бодох бүртгэлд хэрэглэх үндсэн мөнгөн тэмдэгт нь Монгол төгрөг байх ба нэмэлт бүртгэл тооцоондоо бусад гадаад мөнгөн тэмдэгтийг ашиглаж болно.

14.2.3. Компанийн бүхий л нягтлан бодох бүртгэлийн тооцоо, төлбөрийн баримт, данс бүртгэл, тайланг Монгол хэл дээр үйлдэж, хадгална.

**14.3. Санхүүгийн мэдээлэл.** Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн гишүүн болон Хувьцаа эзэмшигч Талуудад дараах мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгнө. Үүнд:

14.3.1. Сар болгоны эцэст аудитаар баталгаажуулаагүй тайлан, мэдээ /санхүүгийн тайлан, бусад холбогдох тайлан мэдээ/ дараа сарын 20-ний өдрийн дотор;

14.3.2. Санхүүгийн жилийн эцэст аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан дараагийн санхүүгийн жилийн 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор;

14.3.3. Тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж зохих хугацаанд хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана. Үүнд:

14.3.3.1. Тайлангийн хугацаанд Компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, түүний үр дүн, бүтэц, зохион байгуулалт, тулгамдсан асуудлууд.

14.3.3.2. Тайлангийн хугацаанд Компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, Гүйцэтгэх удирдлагын зардлын хэмжээ.

14.3.4. Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн аль нэг гишүүнээс шаардсан бусад мэдээлэл.

**14.4. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа**

14.4.1. Компанийн санхүүгийн жил 01-р сарын 01-нээс (эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс) эхлэн 12-р сарын 31-нд (сүүлийн жилийн хувьд Хувьцаа эзэмшигчийн шийдвэрт заасан татан буулгах өдөр) дуусна.

14.4.2. Компани нь аж ахуй, үйлдвэрлэл, санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны статистик тайлан, мэдээ бүртгэлийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтөлж, тайлагнана.

14.4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Монгол Улсын хуулийн дагуу элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцож өртөгт оруулна.

**14.5. Татвар**

14.5.1. Компани Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар, хураамж, эдэлбэр газрын, усны болон бусад төлбөрийг зохих журмын дагуу төлнө.

14.5.2. Компани Талуудад хуваарилагдсан ногдол ашгийг олгохдоо Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу холбогдох татварыг суутган авч зохих журмын дагуу төлнө.

**14.6. Санхүүгийн хяналт**

14.6.1. ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагын тухайн санхүүгийн жилийн үйл ажиллагааг дараа оны 2-р сарын 1-ний дотор үнэлнэ.

14.6.2. Компанийн санхүүгийн болон эдийн засгийн үйл ажиллагаанд хийх шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн санхүүгийн жил дууссаны дараа ээлжит

шалгалтыг хийнэ. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, Хувьцаа эзэмшигчийн шаардсанаар хэдийд ч хийж болно.

#### **АРВАН ТАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА, ТАТАН БУУЛГАХ ҮНДЭСЛЭЛ**

- 15.1. Компанийг хугацаанаас нь өмнө татан буулгаж үйл ажиллагааг дуусгавар болгосноос бусад тохиолдолд компани нь албан ёсоор хуулийн этгээд болсон өдрөөс эхлэн хугацаагүй явуулна.
- 15.2. Энэхүү Дүрмийн 15.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд Хувьцаа эзэмшигчдээс томилогдсон Татан буулгах комисс компанийг татан буулгах ажлыг хариуцан зохион байгуулна.
- 15.3. Дор дурдсан аль нэг нөхцөл байдал үүссэн тохиолдолд компанийн үйл ажиллагааг зогсооно. Үүнд:
- 15.3.1. Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан /Монгол Улсын засгийн газар/
  - 15.3.2. Хувьцаа эзэмшигчид компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн;
  - 15.3.3. Компани дампуурсан, эсвэл төлбөрийн чадваргүй болсон нь шүүхээр тогтоогдсон.
- 15.4. Талууд Компанийг татан буулгахыг зөвшөөрснөөс хойш арван таван (15) өдрийн дотор ТУЗ нь татан буулгах журам болон татан буулгах комисс томилох тухай санал боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар танилцуулна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас татан буулгах саналыг баталж, Компанийг төлөөлөх эрх бүхий татан буулгах комиссыг томилно. Татан буулгах комисс нь Холбогдох хууль болон энэхүү Гэрээний зарчмын дагуу өөрийн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлнэ.
- 15.5. Хэрэв Хувьцаа эзэмшигч компанийн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргавал татан буулгах комисс нь компанийн эд хөрөнгө, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг тухайн үеийн зах зээлийн үнээр борлуулах ба борлуулалтын орлогыг тэргүүн ээлжинд компанийн татвар хураамж, өр төлбөрийг төлж барагдуулахад зориулна.
- 15.6. Татан буулгах комисс нь компанийн татвар хураамж, өр төлбөрийг барагдуулж зохих тооцоог хийснээс хойш 20 хоногийн дотор компанийн үлдэгдэл мөнгөн хөрөнгө, эрх, тусгай зөвшөөрлийг дор дурдсанаар хуваарилна. Үүнд:
- 15.6.1. Үлдэгдэл мөнгөн хөрөнгийг Хувьцаа эзэмшигчид дүрмийн 4.2-т заасан хувь хэмжээнд тэнцүүлэн хуваарилна;
  - 15.6.2. Компанийн аливаа эрх, тусгай зөвшөөрлийг Хувьцаа эзэмшигчид, эсвэл тэдний бичгээр зөвшөөрөл өгсөн этгээдэд шилжүүлнэ.
- 15.7. Татан буулгалтын бүхий л ажиллагааг Холбогдох хуулийн дагуу дуусгавар болгосны дараа татан буулгах комисс нь татан буулгалтын эцсийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар хүргүүлнэ. Талууд нь яаралтай хурал зарлаж тухайн тайланг хэлэлцэж батална.

#### **АРВАН ЗУРГАА. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 16.1. Компанийн Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх удирдлагын бусад ажилтан (Ерөнхий нягтлан бодогч, нэгжийн удирдах албан тушаалтан) зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргах,

гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

16.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ дүрэмд тусгайлан заасан эрх үүргээс гадна үйл ажиллагаандаа дор дурдсан үүргийг хүлээх бөгөөд зөрчсөн тохиолдолд ноцтой зөрчил үйлдсэнд тооцох бөгөөд Гэрээг цуцлах, ажлаас халах үндэслэл болно. Үүнд:

16.2.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ дүрэм, гэрээнд заасан бүрэн эрхийн хүрээнд эрх мэдлээ хэрэгжүүлэх бөгөөд энэ дүрэм, гэрээгээр эрх нь олгогдоогүй бол хориглоно гэсэн зарчмыг хэрэгжүүлэх;

16.2.2. Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, Монгол Улсын хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;

16.2.3. Компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн, үндэслэлтэй шийдвэр гаргах;

16.2.4. Шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухай холбогдох удирдлагад мэдэгдэж, сэргийлэх бүхий л арга хэмжээг авах;

16.2.5. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахыг хориглоно;

16.2.6. Компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн ашиг сонирхлын зорилгоор ашиглахыг тус тус хориглоно;

16.2.7. Компанийн бүх төрлийн өмч хөрөнгө, тусгай зөвшөөрлийг зөвшөөрөлгүйгээр, эсвэл ашиг олох зорилгоор бусдад шилжүүлэх, худалдах, ашиглуулах, барьцаанд тавих, баталгаа гаргах, хөрөнгийг хугацаанаас нь өмнө актлах болон бусад байдлаар ашиглан шамшигдуулахыг хориглоно;

16.2.8. Бараа, ажил үйлчилгээг зах зээлийн үнээс илтэд өндөр үнээр авах, Хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр Их хэмжээний хэлцэл болон Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, Их хэмжээний хэлцлийг нуух зорилгоор дүр үзүүлсэн гэрээ хийх (нэг үргэлжилсэн харилцааг хэд хэдэн гэрээгээр хуваах), Санхүүгийн баримт бичгийг хуурамчаар үйлдэхийг тус тус хориглоно;

16.2.9. Компани болон Хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцох, нэгдэх, зохион байгуулахыг хориглоно;

16.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дор дурдсан үйл ажиллагаа явуулсан бол компани болон Хувьцаа эзэмшигчид учруулсан хохирлыг өөрийн хувийн хөрөнгөөр хариуцна. Үүнд:

16.3.1. Энэ дүрмийн 16.2-т заасан үүргийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл хийсэн;

16.3.2. Хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулсан;

16.3.3. Хувьцаа эзэмшигч болон компанийн зээлдүүлэгч, харилцагчдад хуурамч мэдээлэл өгсөн;

16.3.4. Компанийн тухай Монгол Улсын хуулийн холбогдох зүйлд заасан шаардлагыг зөрчиж нэгдмэл сонирхол бүхий этгээд болохоо мэдэгдэлгүйгээр гэрээ хэлцэл хийсэн;

16.3.5. Компанийн тухай Монгол Улсын хуулийн холбогдох зүйлд заасан журмын дагуу компанийн бичиг баримтыг хадгалаагүй;

## АРВАН ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

- 17.1. Дараах мэдээлэл нь Компанийн нууц мэдээлэлд хамаарах бөгөөд бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хөндлөнгийн аливаа хувь хүн, компани, байгууллагад өгөх, дамжуулахыг хориглоно. Үүнд:
- 17.1.1. Байгууллагын нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомж, компанийн дотоод журамд нууц мэдээлэл гэж заасан бусад мэдээлэл;
  - 17.1.2. Компанийн эрх, тусгай зөвшөөрөл;
  - 17.1.3. Компани, Талууд болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн бизнес төлөвлөгөө, төсөв болон үйл ажиллагаа;
  - 17.1.4. Задруулах үед нууц мэдээлэл гэж тодорхойлогдсон бусад нууц мэдээлэл эсхүл шинж чанарын хувьд нууц мэдээлэлд хамаарах бөгөөд зөвхөн хүлээн авагчид задруулах зорилготой мэдээллийг хамааруулна.
- 17.2. Энэхүү дүрмийн 17.1 дэх заалтыг компанийн үйл ажиллагаа явуулах хугацаанд бүгд мөрдөх ба компанийг татан буулгасан тохиолдолд уг өдрөөс эхлэн 10 жилийн турш хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 17.3. Энэхүү Дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй, эсвэл хуулийн байгууллага шаардаагүй бол Хувьцаа эзэмшигчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Хувьцаа эзэмшигчид, компанийн эрх бүхий албан тушаалтны нэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дурдаж, ашиглахгүй.

## АРВАН НАЙМ. БУСАД

- 18.1. Энэхүү дүрмийг монгол хэлээр 3 (гурван)-н хувь үйлдэнэ.
- 18.2. Энэхүү дүрэмд Хувьцаа эзэмшигчид харилцан тохиролцсоноор нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд ийнхүү оруулсан нэмэлт өөрчлөлт нь энэ дүрмийн салшгүй хэсэг байна.
- 18.3. Энэхүү дүрмээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хувьцаа эзэмшигчдийн гэрээ, зээлийн санхүүжилтийн гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актаар зохицуулна.
- 18.4. Хувьцаа эзэмшигчдийн гэрээ, зээлийн санхүүжилтийн гэрээ нь энэхүү дүрмийн салшгүй хэсэг байна.
- 18.5. Энэ дүрмийн заалт Хувьцаа эзэмшигчдийн гэрээ, зээлийн санхүүжилтийн гэрээний заалттай зөрчилдвөл тухайн гэрээний заалтыг баримтална.

---o0o---

